



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/09

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан "Засаг даргын Тамгын газрын авто машин шинэчлэл"-ийн ажлын даалгавар бэлэн болсон тул ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Л.Жамъяндорж (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)

Гишүүд: Ц.Равданпүрэв (Төрийн байгууллагын төлөөлөл)

З.Буянхишиг (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Х.Эрдэнэбаатар (Иргэний төлөөлөл)

Нарийн

бичиг: Г.Азсайхан (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Л.Жамъяндорж)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Г.Азсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ

8400003 01/17 Tush A/09 Och